

Шатрын хөлөг

$n \times m$ нүдний хэмжээтэй шатрын хөлөг өгөгдсөн.

Та дурын тэгш өнцөгт хэлбэртэй талбайг сонгон авч дотор нь байгаа нүднүүдийн өнгийг эсрэгээр нь солих үйлдлийг хийж чадна.

Ийм үйлдлийг хамгийн багадаа хэдэн удаа хийгээд уг хөлгийн нүднүүдийг бүгдийг нь ижил өнгөтэй болгож чадахыг ол.

Оролт: n ба m бүхэл тоонууд зайгаар тусгаарлагдан өгөгдөнө. ($1 \leq n \leq 50$, $1 \leq m \leq 50$)

Гаралт: Дээрх үйлдлийг хамгийн багадаа хэдэн удаа хийхэд хөлгийн бүх нүд ижил өнгөтэй болохыг илэрхийлэх k тоог хэвлэнэ.

Жишээ

Оролт: 2 2

Гаралт: 2

Тайлбар

Уг 2×2 хөлгийн хар өнгөтэй хоёр нүд тус бүр дээр 1×1 хэмжээтэй тэгш өнцөгтийг авч үйлдлийг хийснээр хөлөг эцэст нь тэр чигээрээ цагаан өнгөтэй болно.